

20. Аав аа, Этиопын дайны үеэр гэр орноо орхин дүрвэсэн ч эх оронруугаа буцаж, тогтвортой, амар амгалан амьдралаар амьдрахад бэрхшээлтэй байгаа хүмүүсийг удирдан чиглүүлж, тайвшруулж, амар амгаланг авчираач. (Иохан 16:33)

21. Бурхан минь, Бурундигийн Бужумбурагийн алслагдсан бүс нутагт үр хүүхэд, хөгширсөн эцэг эхээ тэжээхийн тулд уйгагүй хөдөлмөрлөж буй ядуу эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлээч. (Ис. 40:29–31)

22. Бурхан минь, бид Зимбабвед ажилгүй байгаа эрчүүдийг гэр бүлээ тэжээхийн төлөө ажил олж өгөхийг танаас гуйж байна. (Дуу. 23:1)

23. Аав аа, бид Танзани дахь бэлэвсэн эхнэр, өнчин хүүхдүүдийн төлөө залбирч байна. Тэдэнд өвлөх ёстой эд хөрөнгөө авах арга замыг гаргаж өгнө үү. (Дуу. 146:9)

24. Эзэн минь, Өмнөд Африк дахь эмэгтэйчүүдийн залбирлын амьдралыг хүчирхэгжүүлээч; Тантай хэрхэн харьцаж, таны хүслийн дагуу залбирахыг тэдэнд зааж өгөөч. (Дуу. 25:8–9)

25. Аав аа, Малавигийн эмэгтэйчүүд тантай ойртох тусам, та тэдний хэрэгцээг хангаж, тэд таниас амар амгалан, хайр, итгэл найдварыг олох болтугай. (Ром. 12:12)

26. Эзэн минь, Кени улсын охид, эмэгтэйчүүдийг боловсрол, сургалт, сайн дурын ажилд бүрэн хамруулахад саад болж буй соёлын сэтгэлгээг өөрчилж, хор хөнөөлтэй уламжлалыг арилгахын төлөө бид залбирч байна. (Иер. 24:7).

27. Хойд Этиопын дайнд сүйрсэн олон сургуулийг санхүүжүүлж, сэргээн босгосонд Бурхан танд маш их талархаж байна. Хичээлийн хэрэглэгдэхүүнийг бас өгөх болтугай. (Иаков 1:17)

28. Бурундид эхнэр хүүхдээ хаясан нөхрүүдийн зүрх сэтгэлийг ятгаач, Эзэн минь, Эдгээр гэр бүлүүдэд хайр, нөхөн сэргээлтийг авчираач. (Дуу. 27:10)

29. Аав аа, Зимбабвегийн сургуулиуд дахь хүчирхийллийг зогсоож, тус улсын удирдагчдад мөргөлдөөнийг хүчирхийлэлгүйгээр шийдвэрлэх ур чадварыг эзэмшүүлээрэй. (Езек. 45:9)

30. Бурхан минь, даруу байдал болон бусдыг өөрөөсөө дээгүүр үнэлдэг байдлыг хүлээн авахад туслаач. Бид хувиа хичээсэн, бардам зангаасаа болж үхэж байна, таниас суралцаж амьдархыг хүсэж байна. (Кол. 3:12)

31. Эзэн минь ээ, бид Этиопын урт удаан хугацааны түүхийн дараа Этиопын Сэргэн мандалтын үеийн далангийн ус, цахилгааны төлөө танд маш их талархаж байна.

후원안내

국민은행 851-01-0003-724 북방선교방송

최초 입금 후 사무실로 연락 주시기 바랍니다



Найдвартай  
эмэгтэйчүүд

Сар бүр гаргадаг “Найдвартай эмэгтэйчүүд” залбирлын хуанли  
100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 65,000 гаруй хүн хамтдаа  
залбирч байна.



2023. 7.

## Африк эмэгтэйчүүдийн төлөөх залбирал 1

Яг одоо таны тэргүүнд юу байна вэ? Бид ямар ч нөхцөл байдалд байсан Бурханы нүдээр нөхцөл байдлыг харах нь чухал. Бурханы хүсэл бидний бодлоос өөр байх үед бид залбирч, Бурханы хүслийг сонгох ёстой. Энэ бол дуулгавартай байдал юм. Есүс Энэ дэлхий дээр амьдрахдаа Тэнгэрлэг Эцэгийн хүслийг дуулгавартай дагаж байсан юм.

**TWR Korea 북방선교방송**

서울특별시 관악구 양녕로 15, 월드빌딩 6층  
전화 (02)886-5671 / 이메일 phkorea@twrk.or.kr

1. Аав аа, Зимбабвегийн Цшолотшо хотод охидын боловсролыг нэн тэргүүнд тавьж, тэднийг бага насанд нь гэрлүүлэхгүй байхын төлөө залбирч байна. (Сур. 9:9)

2. Эзэн минь, Танзанийн Маасай нутгийн уншиж чаддаггүй ч таны үгнээс суралцах дуртай эмэгтэйчүүдэд зориулж аудио Библи өгөөч. (Дуу. 119:11)

3. Аав аа, Өмнөд Африк дахь TWR-ийн Найдвар доторх Эмэгтэйчүүд үйлчлэлийн багийнхныг ашиглан хүмүүст хүрч, улмаар тэдний нийгэмлэгийг өөрчлөөч. Ард түмэн, үндэстнийхээ төлөө өдөр бүр шийдвэр гаргахад нь засгийн газрын удирдагчдад мэргэн ухааныг өгөөч. (2 Кор. 5:17).

4. Таны дотор жинхэнэ эрх чөлөө бий, Бурхан минь. Малавид донтолттойгоо тэмцэж буй хүмүүс таниас эрх чөлөөг олох болтугай. (Иохан 8:36)

5. Кени улсын засгийн газар залуу охидод эмэгтэй хүний ариун цэврийн хэрэглэлийг үнэ төлбөргүй олгох хуулийг батлах болтугай. Олон охид нийт 144 долоо хоног хичээллэхээс бараг 24 долоо хоногийг сарын тэмдгийн хэрэглэл хэрэглэх боломжгүйгээс тасалдаг. (Филиппой 2:4)

6. Эзэн минь ээ, Этиоп дахь "Найдвар доторх Эмэгтэйчүүд" үйлчлэлийн төлөө бид таныг магтъя. Хөтөлбөрт хуваалцсан Бурханы үг олон итгэгчдийн амьдралд аврал, өсөлтийг авчирсан билээ. (Евр. 4:12)

7. Бурунди улсад хүнсний бүтээгдэхүүний үнэ огцом нэмэгдсэний улмаас амьжиргааны түвшин доогуур айл өрхүүд хоол хүнс худалдаж авах мөнгөгүй болсон. Бурхан минь, эдгээр гэр бүлүүдийг өлсгөхгүйн тулд тэдний өдөр тутмын хэрэгцээг хангаж өгөөч! (Дуу. 14:6)

8. Аав аа, Зимбабвегийн ард түмэн хуурамч эш үзүүлэгчид болон худал сургаал номлолд биш зөвхөн танд л найдах болтугай. (1 Иохан 4:1-3)

9. Бид 9-р сард Занзибарын Пемба арал дээр үйлчилж эхлэхийн төлөө залбирч байна. Эзэн минь, "Найдвар доторх Эмэгтэйчүүд" нэвтрүүлгийг дамжуулах радио станцыг гаргаж өгнө үү. (Ром. 10:17)



10. Бурхан минь ээ, хар тамхины хүчирхийлэл, зам тээврийн осол, байгалийн гамшгийн улмаас хайртай дотны хүмүүсээ алдан гашуудаж буй Өмнөд Африкийн эмэгтэйчүүдийг тайтгаруулж өгөөч. (Дуу. 23:4)

11. Эзэн минь, бид Малавид амьдарч буй хүмүүсийн эдийн засгийн тогтвортой байдлын төлөө залбирч байна. Тэдний хэрэгцээг хангаж өгөөч. (Флп. 4:19)

12. Аав аа, Кени улсын залуу охидууд бэлгийн харьцаанд орохгүй, бага насандаа гэрлэхгүй байхын төлөө бид залбирч байна. Эрт хүүхэд төрүүлэх нь түүний сургуульд сурах боломжид саад учруулж, хүүхдийн хувьд ч эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлдөг. (Еф. 5:1-3)

13. Эзэн минь ээ, манай Этиоп дахь TWR-ийн Найдвар доторх Эмэгтэйчүүд багийн удирдагчдыг тус нутгийн эмэгтэйчүүдэд сайн үйлчилгээ үзүүлэхийн тулд тасралтгүй санхүүжилтээр хангах стратеги болон хандивлагчдыг өгөөч. (Ром. 8:32).

14. Бурхан минь, Бурундигийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд эдгэрлийг авчираач. Тэдний гэр бүл бүх мөнгөө эмнэлгийн үйлчилгээнд зарцуулж, тэднийг амьд явах ямар ч боломгүй болгосон байна. Тэдэнд туслаач. (Иер. 17:14).

15. Аав аа, бид Зимбабвегийн эд хөрөнгийг сүйтгэж, цахилгааны кабель хулгайлсан хүмүүсийн төлөө залбирч байна. Тэд муу замаасаа эргэж танруу ирэх болтугай. (Еф. 4:28)

16. Бурхан минь, Танзанийн дүрвэгсдийн хуаранд байгаа эмэгтэйчүүдэд хоол хүнс, хувцас хунар, радиогоор хангаж өгөөч, ингэснээр тэд "Найдвар доторх Эмэгтэйчүүд" нэвтрүүлгийг сонсох боломжтой болно. (Лев. 23:22)

17. Аав аа, Өмнөд Африкийн Дорнод Кейп дэх "Найдвар доторх Эмэгтэйчүүд" хөтөлбөрийг хуваалцахын тулд нарны эрчим хүчээр ажилладаг жижиг сонсголын төхөөрөмжүүдийг ашиглах олон арга замуудын талаар манай удирдагчдад хэлээрэй. (Иаков 1:5)

18. Эзэн минь, Малавид гашуудаж буй хүмүүсийг тайвшруулж байгаад тань бид Таныг магтъя. (Мат. 5:4)

19. Бид Кени улсын ард түмний төлөө бороо ороорой гэж хашхирч байна, Бурхан минь. Энэ удаагийн ган гачиг нь олон хүнийг хоол хүнс, усгүй болгож байна. (Ис. 44:3-4)